

# Нийлбэр

Хүслэн 4-р ангид сурдаг. Тэр математикийн хичээлдээ сонирхолтой бөгөөд өгсөн 2 натурал тооны хооронд орших бүх бүхэл тоог нэг цифртэй тоо болтол тоо тус бүрийг түүний цифрүүдийн нийлбэрээр сольж бичжээ. Тухайлбал 197 тоог түүний цифрүүдийн нийлбэр  $1+9+7=17$  тоогоор, дараа нь  $1+7=8$  тоогоор солино.

## Даалгавар:

a-аас b хүртэлх бүх тоог дээрх аргаар солиход үүсэх тоонуудын нийлбэр олно уу.

## Оролт:

Эхний мөрөнд даалгаврын тоо N ( $1 \leq N \leq 100$ ) өгөгдөнө.

Дараагийн N мөр тус бүрд даалгаврын параметр болох a ба b ( $1 \leq a \leq b \leq 2^{60}$ ) натурал тоонууд хоосон зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

## Гаралт:

N даалгавар бүрийн хариуг мөр бүрээр гаргана. Хэвлэх дараалал нь [a, b] завсрын тоо бүрийн өсөх дараалалтай тохирч байх ёстой.

## Оноо:

Нийт 20 онооны тестийн тохиолдлуудад асуулт тус бүрд  $1 \leq a \leq b \leq 9$ .

Нийт 60 оноо бүхий тестийн тохиолдлуудад  $b - a \leq 1000$ .

Үлдсэн 20 оноо бүхий тестийн тохиолдлуудад  $b - a > 1000$ .

## Жишээ:

Оролт	Гаралт
1 1 5	15
2 9 13 44 45	19 17
1 1998 2018	102

**Тайлбар:** 2-р жишээний тохиолдолд

1-р даалгавар: 9, 10, 11, 12, 13 гэсэн 5 тоог  $9, 1+0=1, 1+1=2, 1+2=3, 1+3=4$  гэсэн тоонуудаар солино. Ийнхүү  $9+1+2+3+4=19$  болно.

2-р даалгавар: 44, 45 гэсэн 2 тоог  $4 + 4 = 8$ ,  $4 + 5 = 9$  гэсэн тоонуудаар солино. Ийнхүү  $8 + 9 = 17$  болно.